

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДОА-2026/013/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Батжаргал

Утас: 7058-4207, Цахим хаяг: [batjargalb@audit.gov.mn](mailto:batjargalb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## **АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
5. Аудитын илрүүлэлт .....	10-11
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	12
7. Төлбөрийн акт, албан шаардлага.....	13-15

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2026.02.25 № 97

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
Н.БАЗАРРАГЧАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 89.9 хувиар үнэлж дүгнэсэн байна.

2125020203

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>119,188,962.32</b>	<b>78,194,955.92</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,351,523.08	37,375,926.92
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,351,523.08	319,441.58
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	37,056,485.34
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	35,123,029.00	40,819,029.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,716,647.00	1,716,647.00
35110	Тусгай зориулалттай материал	521,647.00	521,647.00
35130	Эм боох материал	1,195,000.00	1,195,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	33,406,382.00	39,102,382.00
35420	Аж ахуйн материал	22,428,882.00	25,453,882.00
35470	Бусад хангамжийн материал	10,977,500.00	13,648,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,014,767,507.03</b>	<b>5,890,388,216.71</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,014,767,507.03	5,890,388,216.71
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,854,392,507.03	4,730,013,216.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,197,307,566.00	5,249,011,746.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(639,176,213.43)	(742,951,611.15)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,500,000.00	16,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,250,000.00)	(16,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	345,174,607.86	421,068,307.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(185,358,188.99)	(263,145,103.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	193,821,330.01	212,210,330.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,624,673.68)	(159,395,471.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	251,234,657.00	251,234,657.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(196,236,577.74)	(238,019,638.78)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,160,375,000.00	1,160,375,000.00
39301	Програм хангамж	7,820,000.00	7,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,820,000.00)	(7,820,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,160,375,000.00	1,160,375,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,133,956,469.35</b>	<b>5,968,583,172.63</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>47,989,127.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	47,989,127.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	47,989,127.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	20,998,568.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	26,990,559.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	8,708,832.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	18,281,727.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,133,956,469.35</b>	<b>5,920,594,045.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,133,956,469.35	5,920,594,045.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,609,677,423.28	1,609,677,423.28
51101	Өмч: - төрийн	1,609,677,423.28	1,609,677,423.28
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,357,729,459.11	4,144,367,035.39
51210	Өмнөх үеийн үр дүн	4,405,663,181.96	4,357,729,459.11
51220	Тайлант үеийн үр дүн	(47,933,722.85)	(213,362,423.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	166,549,586.96	166,549,586.96
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,133,956,469.35</b>	<b>5,968,583,172.63</b>

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,129,122,317.36</b>	<b>3,156,469,569.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>204,499,032.36</b>	<b>260,707,280.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	204,499,032.36	260,707,280.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,499,032.36	137,137,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,249,000.00	137,137,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		122,548,080.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		1,022,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,924,623,285.00</b>	<b>2,895,762,289.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,612,469,500.00	2,566,508,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,612,469,500.00	2,566,508,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	312,153,785.00	329,254,189.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	219,975,220.00	248,485,186.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,554,000.00	10,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,624,565.00	70,269,003.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,260,731,688.33</b>	<b>3,369,831,992.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,260,731,688.33</b>	<b>3,369,831,992.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,961,239,615.84	3,264,976,858.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,918,424,420.54	2,123,192,948.72
210101	Үндсэн цалин	1,000,696,517.79	1,015,365,664.62
210102	Нэмэгдэл	605,360,741.98	748,170,007.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	200,486,407.99	212,507,592.21
210104	Урамшуулал	111,880,752.78	147,149,684.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	215,863,367.79	272,699,099.03
210201	Тэтгэврийн даатгал	150,541,304.79	195,382,199.03
210202	Тэтгэмжийн даатгал	17,172,445.72	19,364,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,585,772.86	9,679,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,569,982.86	9,661,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,993,861.56	38,611,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,463,900.00	108,409,325.45
210301	Гэрэл, цахилгаан	39,008,300.00	24,589,371.98
210302	Түлш, халаалт	51,038,300.00	60,136,035.13
210303	Цэвэр, бохир ус	38,417,300.00	23,683,918.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	75,795,935.99	59,989,518.00
210401	Бичиг хэрэг	6,530,034.00	4,374,750.00
210402	Тээвэр, шатахуун	12,099,932.00	14,229,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,632,480.99	2,614,494.00
210404	Ном, хэвлэл	-	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	383,600.00	1,936,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,149,889.00	34,834,294.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	139,450,678.50	147,827,215.41
210501	Эм, бөлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,584,451.24	903,438.00
210502	Хоол, хүнс	122,343,927.26	144,736,377.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,522,300.00	2,187,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	40,022,000.00	7,356,710.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,240,000.00	335,000.00
210604	Урсгал засвар	25,382,000.00	7,021,710.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	14,253,000.00	26,824,000.00
210702	Дотоод албан томилголт	14,253,000.00	26,824,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	133,384,454.00	136,645,127.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	114,781,854.00	129,611,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	32,352.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,000,000.00	608,500.00
210807	Газрын төлбөр	6,602,600.00	6,370,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	295,581,859.02	382,032,915.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,737,680.10	104,353,814.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,050,000.00	7,312,930.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	233,794,178.92	270,366,170.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	299,492,072.49	104,855,133.89
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	278,015,035.00	56,131,545.85
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	14,703,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,251,024.00	26,507,045.83
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төлөх үзэмж, дамжлага	209,210,011.00	14,921,500.02
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,104,437.49	48,723,588.04
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,104,437.49	48,697,715.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,872.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(131,609,370.97)</b>	<b>(213,362,423.72)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(137,002,714.24)</b>	<b>(213,362,423.72)</b>

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>3,129,122,317.36</b>	<b>3,032,899,289.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>204,499,032.36</b>	<b>137,137,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	204,499,032.36	137,137,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,499,032.36	137,137,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	126,249,000.00	137,137,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,924,623,285.00</b>	<b>2,895,762,289.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,612,469,500.00	2,566,508,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,612,469,500.00	2,566,508,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	312,153,785.00	329,254,189.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	219,975,220.00	248,485,186.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	25,554,000.00	10,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	66,624,565.00	70,269,003.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,044,826,341.49</b>	<b>3,090,174,899.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,044,826,341.49</b>	<b>3,090,174,899.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,745,334,269.00</b>	<b>2,962,966,280.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,918,424,420.54	2,123,192,948.72
210101	Үндсэн цалин	1,000,696,517.79	1,015,365,664.62
210102	Нэмэгдэл	605,360,741.98	748,170,007.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	200,486,407.99	212,507,592.21
210104	Урамшуулал	111,880,752.78	147,149,684.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	219,214,890.87	269,667,017.53
210201	Тэтгэврийн даатгал	150,541,304.79	192,350,117.53
210202	Тэтгэмжийн даатгал	17,172,445.72	19,364,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,585,772.86	9,679,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,569,982.86	9,661,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,345,384.64	38,611,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,463,900.00	108,409,325.45
210301	Гэрэл, цахилгаан	39,008,300.00	24,589,371.98
210302	Түлш, халаалт	51,038,300.00	60,136,035.13
210303	Цэвэр, бохир ус	38,417,300.00	23,683,918.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,209,734.99	54,772,496.00
210401	Бичиг хэрэг	6,421,934.00	4,374,750.00
210402	Тээвэр, шатахуун	12,529,450.00	13,429,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,632,480.99	2,614,494.00
210404	Ном, хэвлэл	-	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	808,520.00	1,936,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,817,350.00	30,417,272.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	150,700,688.50	131,336,047.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,779,451.24	903,438.00
210502	Хоол, хүнс	123,598,937.26	128,123,209.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	22,322,300.00	2,309,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,782,000.00	6,049,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,500,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	27,882,000.00	3,649,400.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	14,253,000.00	23,116,600.00
210702	Дотоод албан томиллолт	14,253,000.00	23,116,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	138,770,454.00	134,878,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,817,854.00	127,845,448.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	32,352.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,350,000.00	608,500.00
210807	Газрын төлбөр	6,602,600.00	6,370,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	72,515,180.10	111,543,544.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,465,180.10	101,480,614.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,050,000.00	10,062,930.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>299,492,072.49</b>	<b>127,208,619.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	278,015,035.00	41,428,545.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	48,251,024.00	26,507,045.83
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	209,210,011.00	14,921,500.02
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	37,056,485.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	37,056,485.34
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,</b>	12,104,437.49	48,723,588.04
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,104,437.49	48,697,715.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,872.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>84,295,975.87</b>	<b>(57,275,610.24)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>36,714,900.00</b>	<b>23,438,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>36,714,900.00</b>	<b>23,438,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	36,714,900.00	23,438,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,714,900.00	23,438,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(36,714,900.00)</b>	<b>(23,438,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	47,581,075.87	(80,714,410.24)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	80,714,410.24

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	1,609,677,423.28	166,549,586.96	4,357,729,459.11	6,133,956,469.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,609,677,423.28</b>	<b>166,549,586.96</b>	<b>4,357,729,459.11</b>	<b>6,133,956,469.35</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,609,677,423.28</b>	<b>166,549,586.96</b>	<b>4,357,729,459.11</b>	<b>6,133,956,469.35</b>
D01	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,609,677,423.28</b>	<b>166,549,586.96</b>	<b>4,357,729,459.11</b>	<b>6,133,956,469.35</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,609,677,423.28</b>	<b>166,549,586.96</b>	<b>4,357,729,459.11</b>	<b>6,133,956,469.35</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-213,362,423.72	-213,362,423.72
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,609,677,423.28</b>	<b>166,549,586.96</b>	<b>4,144,367,035.39</b>	<b>5,920,594,045.63</b>

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,774,290,600.00	2,611,448,395.33
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,774,290,600.00	2,611,448,395.33
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,722,033,400.00	2,570,019,849.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,971,168,200.00	1,963,231,789.62
210101	Үндсэн цалин	978,467,900.00	974,837,654.62
210102	Нэмэгдэл	635,014,000.00	628,736,858.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	217,018,700.00	212,507,592.21
210104	Урамшуулал	140,667,600.00	147,149,684.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	251,106,100.00	251,106,100.00
210201	Тэтгэврийн даатгал	173,789,200.00	173,789,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,364,900.00	19,364,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,679,200.00	9,679,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,661,000.00	9,661,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,611,800.00	38,611,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	157,949,700.00	108,409,325.45
210301	Гэрэл, цахилгаан	28,302,000.00	24,589,371.98
210302	Түлш, халаалт	101,770,200.00	60,136,035.13
210303	Цэвэр, бохир ус	27,877,500.00	23,683,918.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,951,500.00	20,810,992.00
210401	Бичиг хэрэг	1,931,500.00	1,869,750.00
210402	Тээвэр, шатахуун	3,175,600.00	2,666,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,155,000.00	2,004,494.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,950,300.00	1,936,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,739,100.00	12,333,898.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	175,860,500.00	131,229,279.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,550,000.00	796,670.00
210502	Хоол, хүнс	170,015,500.00	128,123,209.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,295,000.00	2,309,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,984,000.00	4,793,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,583,500.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	5,400,500.00	2,393,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	24,306,600.00	22,306,600.00
210702	Дотоод албан томилолт	24,306,600.00	22,306,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй</b>	109,640,800.00	94,819,752.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	99,891,100.00	87,786,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,100.00	32,352.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,900.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,433,500.00	608,500.00
210807	Газрын төлбөр	6,370,600.00	6,370,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	66,000.00	(26,687,689.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,000.00	(26,687,689.00)
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52,257,200.00	41,428,545.85
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	52,257,200.00	41,428,545.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,513,200.00	26,507,045.83
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,744,000.00	14,921,500.02
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	59.00	59.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	37.00
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>329,254,189.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>329,228,316.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>329,228,316.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>159,961,159.10</b>
210101	Үндсэн цалин	40,528,010.00
210102	Нэмэгдэл	119,433,149.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,560,917.53</b>
210201	Тэтгэрийн даатгал	18,560,917.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,731,504.00</b>
210401	Бичиг хэрэг	2,505,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,763,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	610,000.00
210404	Ном, хэвлэл	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,853,374.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,196,768.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,196,768.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,055,700.00</b>
210602	Тавилга	12,800,000.00
210604	Урсгал засвар	1,255,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>810,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	810,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,059,148.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	40,059,148.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,853,120.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,790,190.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,062,930.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>25,872.37</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлтийн төвлөрүүлэх шилжүүлэг	25,872.37
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>329,254,189.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>329,254,189.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	248,485,186.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	<b>70,269,003.00</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,368.6 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 379.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага, 47,989.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 48,368.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,100.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

- 5.1.1. Томилолтоор ажилласан албан хаагчид цалингийн зардлаас хоолны хөнгөлөлтийг давхардуулж 60.0 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, Засгийн газрын 2019 оны 06 тоот тогтоол төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам 2.2. “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал.” гэсэн заалттай зөрчсөн тул төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.
- 5.1.2. Нийгмийн даатгалын хэлтэст шимтгэлийн 319.4 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.” гэж заасныг зөрчсөн тул төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

- 5.2.1. Халхгол сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдсон сумандаа байрлан ажиллахгүй, ХХҮГ-т байрлан зайнаас ажиллаж байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 “Ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулна.” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул зөрчил арилгах албан шаардлага өгөв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- 5.3.1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

**Илрүүлэлт:** Тус газар нь тайлант онд 47.9 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь Ахмадын сувиллын зарцуулах эрх 12 дугаар сард нээгдээгүй, бүтэц орон тооны цомхотголтой холбоотой ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн тэтгэмжийг ХХҮЕГ-аас төсөвт нэмж өгөөгүй зэргээс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өглөгийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах.

- 5.3.2. Цалингийн зардалтай холбоотой

**Илрүүлэлт:** Өндөр насны тэтгэвэрт гараад ажиллаж байгаа асрагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл 25 хувиар олгосон байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөдөлмөрийн гэрээгээ хийхдээ нийт хөлсөө тохирон гэрээндээ тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан. Харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Томилолт, хоол унаа давхардуулан олгосон	1	60.0	1	60.0	-	-	-	-	-	-	-	-	-
НДШ илүү шилжүүлсэн	1	319.4	1	319.4	-	-	-	-	-	-	-	-	-
Ажлын байранд дээрээ ажиллаагүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Өглөг барагдаагүй	1	47,989.1	-	-	-	-	1	47,989.1	-	-	-	-	-
Тэтгэвэрт гарсан хүнд ТАХ нэмэгдэл өгсөн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>48,368.6</b>	<b>2</b>	<b>379.4</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>47,989.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/31 АН60303

Чойбалсан хот

2026-2026/013/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халхгол сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн томилогдсон сумандаа байрлан ажиллахгүй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт зайнаас ажиллаж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 "Ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас ажиллуулна." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Зөрчлийг таслан зогсоож, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан сумын мэргэжилтнийг томилогдсон суманд ажиллуулах, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.НАРМАНДАХ

АХЛАХ АУДИТОР  Б.БАТЖАРГАЛ



2126030046



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 02/27 А/160303

Чойбалсан хот

20А-2026/013/НА-СТА-ТШЗ

Г

Г

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын хэлтэст шимтгэлийн 319.4 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5 "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5 "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү шилжүүлсэн 319,441.0 /Гурван зуун арван есөн мянга дөрвөн зуун дөчин нэгэн/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.НАРМАНДАХ

АХЛАХ АУДИТОР  Б.БАТЖАРГАЛ



2126110051



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/26 АНБДЗ03

Чойбалсан хот

20А-2026/013/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтоор ажилласан албан хаагчид цалингийн зардлаас хоолны хөнгөлөлтийг давхардуулж 60.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Засгийн газрын 2019 оны 06 тоот тогтоол төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам 2.2. "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал." гэсэн заалттай зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5 "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү олгосон 60,000.0 /Жаран мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ  
Б.БАТЖАРГАЛ



2126110048